



## **"БЭСТ ФОРТУНА АУДИТ" ХХК**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо,  
"Монгол эмимпекс концерн" ХХК-ийн байр, 200 тоот  
Утас: 324338, 89116465,  
98056465, 98006465  
И-мэйл: fortune\_audit@yahoo.com

2019.02.28 № 52  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### **ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

#### **Аудиторын санал дүгнэлт**

Бид "Асби" ХК-ийн 2018 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд болон бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн байдал, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангуудыг бэлтгэхдээ СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан Монгол улсын Сангийн сайдын тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

#### **Дүгнэлтийн үндэслэл**

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн хувьд баримталсан зарчим, сонгож хэрэглэсэн арга, дотоод хяналтын системийг судлав. Санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэл бүхий нотолгоо олж авах зорилгоор аудитын түүврийн болон бусад арга горимуудыг гүйцэтгэсэн бөгөөд бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж итгэж байна.

#### **Санхүүгийн тайлангийн талаар удирдлагын хүлээх үүрэг хариуцлага**


Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаа зөрчилгүй бэлтгэж, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож хэрэглэх, шударгаар толилуулахтай холбоотой, зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

## **Аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт өгөх явдал юм. Бид АОУС-ын дагуу аудитаа хийж гүйцэтгэсэн болно. Ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөн, санхүүгийн тайлангууд материаллаг алдаатай эсэх талаар ул үндэстэй баталгаажуулалт олж авахын тулд аудитыг төлөвлөж гүйцэтгэхийг эдгээр стандартууд биднээс шаарддаг.

Аудитаар санхүүгийн тайлангууд дахь дүнгүүд болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэдэг. Сонгосон горимууд нь аудиторын үнэлэмж, түүний дотор залилан эсвэл алдаанаас шалтгаалсан санхүүгийн тайлангууд дахь материаллаг алдаатай тайлагналын эрсдлийн үнэлгээнээс хамаардаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхдээ аудитор нь тухайн байгууллагын дотоод хяналтын үр өгөөжийн талаар дүгнэлт гаргах зорилго тавилгүйгээр, тухайн нөхцөл байдалд тохиромжтой аудитын горимуудыг сонгохын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэж үнэн зөв толилуулахтай хамаатай дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн аудитаар тухайн хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал болон тооцоололын ул үндэслэлийг үнэлж, мөн санхүүгийн тайлангуудын нийт тодруулгыг үнэлдэг.

ЗАХИРАЛ



Ж. ОЮУНЦЭЦЭГ

**2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ  
АУДИТЛАГДСАН ТАЙЛАН ТЭНЦЭЛ**

(мянган төгрөг)

Үзүүлэлтүүд	2018-12-31	
	Аудитлагдаагүй	Аудитлагдсан
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	6,361.3	6,361.3
Дансны авлага		-
Татвар, НДШ-ийн авлага	2,871.7	2,871.7
Бусад авлага		-
Бусад санхүүгийн хөрөнгө		-
Бараа материал	1,947.0	1,947.0
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		-
Санхүүгийн хөрөнгө		-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус		
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>11,180.0</b>	<b>11,180.0</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	310,776.8	310,776.8
Биет бус хөрөнгө	11,800.0	11,800.0
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		-
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		-
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>322,576.8</b>	<b>322,576.8</b>
	<b>333,756.8</b>	<b>333,756.8</b>
<b>Нийт хөрөнгийн дүн</b>		
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ</b>		
<b>Өр төлбөр</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Дансны өглөг		-
Цалингийн өглөг		-
Татварын өглөг	4,573.4	4,573.4
ЭМ, НДШ-ийн өглөг		-
Богино хугацаат зээл	20,656.0	20,656.0
Хүүгийн өглөг		
Урьдчилж орсон орлого	10,223.6	10,223.6
Бусад богино хугацаат өр төлбөр	214,374.1	214,374.1
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>249,827.1</b>	<b>249,827.1</b>
Урт хугацаат зээл		-
Нөөц /өр төлбөр/		-
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
	<b>249,827.1</b>	<b>249,827.1</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>		
<b>Эзэмшигчийн өмч</b>		
<b>Өмч: а) Төрийн</b>		
б) Хувийн		-
в) Хувьцаат	238,342.2	238,342.2
Нэмж төлөгдсөн капитал	215,065.1	215,065.1
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	324,000.0	324,000.0
Эздийн өмчийн бусад хэсэг		-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(693,477.6)	(693,477.6)
<b>Эзэмшигчийн өмчийн дүн</b>	<b>83,929.7</b>	<b>83,929.7</b>
	<b>333,756.8</b>	<b>333,756.8</b>
<b>Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн дүн</b>		

"АСБИ" ХК

2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН АУДИТЛАГДСАН  
ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

(мянган төгрөг)

Үзүүлэлтүүд	2018-12-31	
	Аудитлагдаагүй	Аудитлагдсан
Борлуулалтын орлого	53,435.2	53,435.2
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		-
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>53,435.2</b>	<b>53,435.2</b>
<b>Үйл ажиллагааны зардал</b>		
Бусад үйл ажиллагааны орлого		-
Хүүгийн орлого		-
Ноогдол ашгийн орлого		-
Эрхийн шимтгэлийн орлого		-
Бусад орлого	769.0	769.0
Борлуулалт маркетингийн зардал		-
Ерөнхий ба удирдлагын зардал	48,895.0	48,895.0
Санхүүгийн зардал		-
Бусад зардал		-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		-
Бусад ашиг (алдагдал)		-
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>5,309.2</b>	<b>5,309.2</b>
Орлогын татварын зардал	530.9	530.9
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>4,778.3</b>	<b>4,778.3</b>
<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>4,778.3</b>	<b>4,778.3</b>
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
<b>Орлогын нийт дүн</b>	<b>4,778.3</b>	<b>4,778.3</b>

АУДИТЛАГДАГЧИЙН ТАЙЛАН  
АУДИТЛАГДСАН  
2018.12.31

"АСБИ" ХК

**2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН  
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

(мянган төгрөг)

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдс ан ашиг (алдагдал)	Нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл</b>	<b>238,342.2</b>	<b>1,217,289.5</b>	<b>324,000.0</b>		<b>(698,255.9)</b>	<b>1,081,375.8</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт						-
Өмнөх залруулсан үлдэгдэл	238,342.2	1,217,289.5	324,000.0	-	(698,255.9)	1,081,375.8
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт (бууралт)						
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт (бууралт)						
Хандивын капитал						
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз						
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					4,778.3	4,778.3
Бусад дэлгэрэнгүй орлого						-
Өмчид гарсан өөрчлөлт		(1,002,224.4)				(1,002,224.4)
Ногдол ашиг						
Гаргасан хувьцаат капитал						
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
<b>2018 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл</b>	<b>238,342.2</b>	<b>215,065.1</b>	<b>324,000.0</b>	-	<b>(693,477.6)</b>	<b>83,929.7</b>



"АСБИ" ХК

2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН  
ГҮЙЛГЭЭНИЙ АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

(мянган төгрөг)

Үзүүлэлтүүд	2018-12-31	
	Аудитлагдаагүй	Аудитлагдсан
<b>Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>69,393.8</b>	<b>69,393.8</b>
Борлуулалтын болон худалдан авагчдаас орсон мөнгө	68,624.8	68,624.8
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Буцаан авсан албан татвар	769.0	769.0
Бусад мөнгөн орлого	<b>46,103.0</b>	<b>46,103.0</b>
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		
Ажиллагсдад олгосон мөнгө	-	-
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	3,542.0	3,542.0
Бараа, материал худалдан авахад төлсөн	5,745.7	5,745.7
Ашиглалтын зардалд төлсөн	19,696.2	19,696.2
Шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	1,864.3	1,864.3
Хүүний төлбөрт төлсөн	9,136.5	9,136.5
Татварын байгууллагад төлсөн	-	-
Даатгалын байгууллагад төлсөн	-	-
Бусад мөнгөн зарлага	6,118.3	6,118.3
	<b>23,290.8</b>	<b>23,290.8</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
Урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
Хүлээн авсан хүүний орлого	-	-
Бусад мөнгөн орлого	<b>22,990.0</b>	<b>22,990.0</b>
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>22,990.0</b>	<b>22,990.0</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
Бусад мөнгөн зарлага	-	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(22,990.0)</b>	<b>(22,990.0)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	-	-
Төрөл бүрийн хандив	-	-
Бусад мөнгөн орлого	<b>13,260.2</b>	<b>13,260.2</b>
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>13,260.2</b>	<b>13,260.2</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	-	-
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	-	-
Төлсөн ногдол ашиг	-	-
Бусад мөнгөн зарлага	<b>(13,260.2)</b>	<b>(13,260.2)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(12,959.4)</b>	<b>(12,959.4)</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>19,320.7</b>	<b>19,320.7</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>6,361.3</b>	<b>6,361.3</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		